

**ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ЗӨВЛӨЛИЙН
БҮРЭЛДЭХҮҮНД НЭР ДЭВШҮҮЛЭХ ТАЛААР
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНООС
ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 01 дүгээр
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн С.Дэмбэрэл**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Үндэсний статистикийн хороонд албан ёсны статистикийн үйл ажиллагаа явуулахад туслах, арга зүйн нэгдмэл байдлыг хангах асуудлаар зөвлөх чиг үүрэгтэй ажилладаг Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх шаардлага гарсаны дагуу Эдийн засгийн байнгын хороо 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа Үндэсний статистикийн хорооны Зөвлөлийн бүрэлдэхүүнд нэр дэвшигчийн асуудлыг авч хэлэлцлээ.

Статистикийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3 дахь хэсэгт “Зөвлөлийн дарга нь Үндэсний статистикийн хорооны дарга байна. Зөвлөл нь 7 хүний бүрэлдэхүүнтэй байх ба 3 гишүүнийг Улсын Их Хурлын холбогдох байнгын хороо, 3 гишүүнийг Засгийн газар санал болгож Улсын Их Хурал томилно.” гэж заасны дагуу Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос тус Зөвлөлийн бүрэлдэхүүнд Монголбанкны Дэд ерөнхийлөгч Э.Батшугар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимиин орлогч дарга М.Оюунчимэг, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Батсайхан нарыг санал болгосныг хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэй дэмжлээ.

Нэр дэвшигчийн танилцуулга болон тогтоолын төслийг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн бүрэлдэхүүнд нэр дэвшигчийн асуудлаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн, Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай Улсын Их хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

~~ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА~~ **Б.ГАРАМГАЙБААТАР**

